



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 1/33

Арвайхээр сум

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 165 дугаар захирамжаар батлагдсан “Нэрэмжит шагналын журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Төрийн албанд олон жил үр бүтээлтэй ажиллаж, аймаг орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж буй аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга Б.Цэнгэл, Гучин-Ус сумын Тамгын газрын дарга Н.Тунгалаг нарыг Богд хаант Монгол Улсын анхны Ерөнхий сайд агсан Т.Намнансүрэнгийн нэрэмжит “Төрийн шилдэг түшээ” тэмдгээр шагнасугай.

2.Шагналд дагалдах “Төрийн шилдэг түшээ” тус бүр 100,000 (нэг зуун мянга), нийт 200,000 (хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0173